

БУСДЫН ЭД ЗҮЙЛИЙГ САНААТАЙ УСТГАХ ГЭМТЭЭХ ГЭМТ ХЭРГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

THEORY AND PRACTICE ISSUES OF THE CRIME OF INTENTIONALLY DESTROYING AND DAMAGING OTHERS' PROPERTY



Э.ЧУЛУУНЦЭЦЭГ

МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн Эрх зүйн багш, хууль
зүйн магистр

CHULUUNTSETSEG E.

Master of Law, Lecturer, Department of Social Science,
School Of Humanities And Social Science Of Mongolian
National University Of Education

Товч агуулга: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх” гэмт хэргийн зүйлчлэлийн онол, практикийн асуудлыг тодорхой болгох, тухайн зохицуулалтын зарим хэсгийг өөрчлөх, дээд шүүхээс дэлгэрэнгүй тайлбар гаргах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай нь шүүхийн практикаас ажиглагдаж байна. Учир нь тухайн зүйлийн зарим нэг тодорхой бус зохицуулалтаас хуулийн практик хэрэглээнд ойлгомжгүй байдал үүсэж, цаашлаад эрүүгийн ял, шийтгэл бодит бус болох, хувь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх тохиолдол олон байгаа билээ. Иймээс энэхүү өгүүллийн хүрээнд тухайн зохицуулалтыг боловсронгуй болох талаар зарим нэг санал дэвшүүлэхийг эрмэлзлээ.

Abstract: There are essential needs practically which are to precise classification theory and practical issues of the crime is “intentionally destroy and damage others’ property” is specified in Article 153 of the Criminal Code, to change some parts of the regulation and to get a detailed description of the Supreme Court. Because practical application of the law created confusion, as well as criminal penalty is not real, individual rights and freedoms are violated in many cases. Therefore, this article attempted to propose some suggestions to improve coordination.

Түлхүүр үгс: гэмт хэрэг, хор уршиг, хохирол, зүйлчлэл, устгах, гэмтээх

Key words: crime, harm, damage, issuance, classification, destroy or damage

Эх газрын эрх зүйн тогтолцоотой гэгдэх манай орны хувьд шүүхийн болон хууль хяналтын байгууллагын эрх зүйн хэрэглээний практикт мэргэжлийн хамтлагийн ёсчилсон мэдлэгт бага ч болов хандахгүйгээр позитив хуулийн хэм хэмжээг туйлчлан үзэх нь “хүний эрхийг хамгаалах” гэх эрх зүйн гол зорилгыг орхигдуулах нөхцөл байдал үүсэх тохиолдол цөөнгүй байна. Үүний нэг тод жишээ нь манай Эрүүгийн хуулийн тусгай ангийн 7 дугаар хэсэг, 19 дүгээр бүлэг дэх өмчийн

эсрэг гэмт хэргийн нэг буюу 153 дугаар зүйлд “бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх” гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал гэдэгтээ олон судлаачид санал нийлэх биз ээ.

Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлийн 153.1-д “Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 153.2-т “Энэ гэмт хэргийг галдан шатаах буюу нийтэд аюултай бусад аргаар үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж зохицуулсан.

Энэ зохицуулалтын дагуу бол гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь шууд санаатай, сэдэлтийн хувьд өс хонзонгийн болон хувийн сэдэлтэй, объектив талын шинжид хохирлын хэмжээ заагаагүй, эд хөрөнгө, устсан, гэмтсэн байх үр дагавар үүссэн, хор уршиг учирсан байхыг шаарддаг. Мөн субъект нь 14 насанд хүрсэн байх, объект нь бусдын өмчлөх эрх, халдлагын зүйл нь устсан гэмтсэн эд зүйл байх бөгөөд хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилсан байна. Хууль хэрэглэх үүрэг бүхий практик хуульчдын хувьд бусдын эд зүйлийг устгах, гэмтээх гэмт хэргийн бүрэлдэхүүний дээрх шинжүүдийг л түлхүү анхаарч, тухайн зүйл заалтын суурь үзэл баримтлал, онол зарчмыг үл анзаарч, мөн субъектив талын шинжийг голчлон үзэх зэрэг хэт позитивист хандаж байгаа нь ажиглагдаж байна.

Тухайлбал, Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхээс 2015.01.09 өдрийн шийтгэх тогтоолоор иргэн А гэгч 7 сартай жирэмсэн эмэгтэй 2014.08.16-ны өдөр эмнэлэгт үзүүлж явсан бөгөөд түүний машиныг иргэн Б гарах гарцгүй болгож хааж зогссон машинаа холдуул гэхэд зүй бус, ааш авир гаргасан тул маргаж газраас 2 ширхэг жижиг чулуу авч машины капот хэсгийн газар шийдсэн маш бага хэмжээтэй будаг халцарч, бага зэрэг хонхойж машинд гэмтэл учирсан, хохирлын хэмжээг хохирогч 110000 /зуун арван мянга/ төгрөг гэж тооцсон тул төлж барагдуулсан байна. Энэ зөрчлийг эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлийн 153.1-д заасан бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх хэргээр зүйлчлэн хэргийг шийдвэрлэн А-д 1 жил 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулсан,¹ мөн Говь Алтай аймгийн сум дундын шүүхийн 2012.03.01-ны өдрийн шийтгэх тогтоолоор иргэн Ц-г иргэн Т-гийн ..телевизийн антен, халуун сав,хуванцар сав, аяга 3ш, хуванцар сандал 3ш, сав хуванцар зэргийг хагалж эвдэлж ,оёдлын машины хайрцаг задалсан гэх гэмт үйлдэлд нь 153 дугаар зүйлийн 153.1-д заасан гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж 2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан.² Тус хэргийн хохирлын хэмжээ 28000 /хорин найман мянга/ төгрөг байсан байна. Энэ мэт бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан гэмт хэргийн бус эрх зүйн зөрчилд эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлд заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж хүнд ял шийтгэл оногдуулж байгаа нь эрх зүйн суурь үнэт зүйл буюу шударга ёсны, хүнлэг, энэрэнгүй байх, үйлдэлд тохирсон шийтгэл оногдуулах зэрэг олон зарчим зөрчсөн шийдвэр гаргаж байна гэж дүгнэж болох юм.

¹ Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол №33 /энэ хэрэг Эрүүгийн хэргийн ДЗШ-ны 10 дугаар шүүхийн 2015.03.03-ний өдрийн 155 дугаартай магадлалаар хэрэгсэхгүй болсон/

² <http://www.court.go.gov.mn>

Хууль зүйн ухааны доктор Н.Лүндэндорж өөрийн бүтээлдээ “Монголын эрх зүйн онолын сэтгэлгээнд гарч буй плюралист хандлагыг харуулах үүднээс манай эрдэмтэн судлаачдын дунд жам ёсны онолын, позитив онолын, эрх зүйн цэвэр онолын, либертари онолын аль аль талыг баримтлагчид, судалгаа сургалтандаа түлхүү ашиглагчид байгаа бөгөөд орчин үед дэлхий дахинаа хүчээ авч байгаа чиглэлүүдээс илүү позитивист онолын талыг баримтлагчид илүү жин даржбайгаа мэт санагдана...”³ хэмээн өгүүлжээ. Судлаачид гэхээсээ илүү практик хуульчид позитивист чиг баримжаатай байх нь хувь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх болон нийгэм дэх шоронжих үзэгдлийн гол шалтгаан төдийгүй бодит хор уршигтай болох нь дээрх тохиолдлуудаас анзаарагдаж байна.

Гэтэл эрүүгийн эрх зүй судлаачид эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлийн зүйлчлэлийн асуудлыг маш сайн судлан онолын олон тайлбар зөвлөмжүүдийг боловсруулжээ. Тухайлбал, шинжлэх ухааны доктор С.Жанцан “устгах гэдэг нь эд зүйл дахин ашиглах ямар ч боломжгүй болсон байхыг хэлнэ” гэж тухайн гэмт хэргийн объектив талын зайлшгүй байх шинжийг тодорхойлсон.

Судлаач Б.Ганболд Монгол улсын эрүүгийн эрх зүй бүтээлдээ: “гэмтээх гэдэг нь тухайн эд зүйлийг сэргээн засварлахгүйгээр ашиглах боломжгүй болгосон байхыг ойлгоно”.⁴ Улсын дээд шүүхийн албан бус тайлбарт “устгах гэдэг ойлголтод эд зүйл өмч хөрөнгийн биет байдалд үйлчилсэн гадны хүчин зүйлийн үр дүнд биет байдлын хувьд бүрэн устгагдаж, эсхүл дахин ашиглах хэрэглэгдэх ямар ч боломжгүй анхны шинж чанар байдлаа бүрэн алдахыг хэлнэ. Устгах нь галдан шатаах хүчилд уусгах, машин механизм ашиглаж эвдэж нураах, гэх мэт хэлбэрээр үйлдэгддэг. Устгах зүйлдлийн улмаас эд хөрөнгийг засаж засварласан боловч анхны байдалд оруулж сэргээх бололцоогүй, мал амьтны хувьд эмчилгээгүй болон аж ахуйн эргэлтээс бүрэн гарсан байдаг. Гэмтээх гэдэг ойлголтод эд зүйл, өмч хөрөнгийн биед байдалд үйлчилсэн гэмт үйлдлээс шалтгаалан ашигтай байдал нь муудаж, чанар үр дүн нь алдагдсан түр хугацаагаар зориулалтаар нь ашиглах хэрэглэх бололцоогүй болохыг хэлнэ. Гэвч дээрх гэмтлийг засвар үйлчилгээгээр сэргээн босголтын үед анхны байдалд нь оруулж болдог”⁵ хэмээн тайлбарласан байна.

Судлаач Г.Бямбадорж өөрийн судалгааны өгүүлэлдээ тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн зүйлчлэлийн асуудалд олон чухал санаа дэвшүүлсэн байна. Үүнд:

Бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх гэмт хэргийн халдлагын зүйл нь хүний гараар бүтээгдсэн зүйл байдаг тул бусад ойролцоо төрлийн гэмт хэргээс буюу эрүүгийн хуулийн тусгай ангийн 210 дугаар зүйлээс ялган зүйлчлэх, бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх гэмт хэрэг нь зөвхөн санаатай, идэвхтэй үйлдлээр илэрдэг тул эрүүгийн хуулийн тусгай ангийн 219 дүгээр зүйлээс ялгаатай, эрүүгийн хуулийн тусгай ангийн 226 дугаар зүйлд заасан “компьютрын мэдээллийн программыг өөрчлөх, эдвэх, сүйтгэх” гэмт хэргээс халдлагын зүйлээрээ, бусдын эд зүйлийг устгах гэмтээх гэмт хэрэг нь хор уршиг учруулснаар бүрэлдэхүүн төгсдөг материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхад эрүүгийн хуулийн тусгай ангийн 243 дугаар зүйлд заасан “баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягтийг хулгайлах, устгах, гэмтээх, нуух” гэмт хэрэг нь дээрх үйлдлүүдийн аль нэгийг

³ Н.Лүндэндорж. “Монголын төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага” УБ.,2002 он 247 дахь талаас

⁴ Ганболд.Б, “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” УБ.,2006 он, 219 дэх тал

⁵ Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар, УБ.,2013 он, хуудас 385

хийснээр бүрэлдэхүүн төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнээрээ тус тус ялгарна.

Мөн эрүүгийн хуулийн тусгай ангийн 282 дугаар зүйлд заасан “цэргийн эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх гэмт хэргээс объектоороо болон заасан хэргийн субъект тусгай субъект байдаг тул субъектийн хувьд ч ялгаатай болохыг тодорхойлсон байна. Ийнхүү тухайн гэмт хэргийн ойролцоо төрлийн буюу эрүүгийн хуулийн тусгай ангийн 210, 213, 219, 226, 234, 282 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулаагүй бүх тохиолдолд 153 дугаар зүйлд заасан гэмт хэргээр зүйлчилнэ.

Мөн бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх гэмт хэргийг хууль тогтоогч материаллаг бүрэлдэхүүнтэй хуульчилсан бөгөөд бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх үйлдлийн улмаас Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хор уршиг учирсан тохиолдолд 153 дугаар зүйлд заасан гэмт хэрэг болох бөгөөд хохирлын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү буюу түүнээс их байна гэж үзсэн. Үүний зэрэгцээ 153.2 дугаар зүйлийн “хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол” гэх гэсгийг хасч эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-дахь хэсгийн 91.2.18-д тусгах⁶ талаар өөрийн санал, судалгааны дүгнэлтээ гаргаж онолын тайлбар өгсөн нь энэ гэмт хэргийн зүйлчлэлийг ихээхэн тодорхой болгосон байна.

Гавьяат хуульч Б.Чимэд “Манай хууль хяналтын байгууллагынхан эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх гэмт хэргийн бүрэлдэхүүн болоод зүйлчлэлийн асуудлыг маш зөв ойлгож болгоомжтой хэрэглэх хэрэгтэй байна. 2012 оны 7 сарын 1-ний үйл явдалтай холбоотой эрүүгийн хуулиар ял сонссон олон хүмүүсийг эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлээр зүйлчлэн ялласан нь онолын үндэслэлгүй юм. Учир нь тэд зүгээр гэртээ сууж байгаад намын байрыг галдан шатаая, эвдэн сүйтгээ, устгая, гэмтээ гэсэн шууд санаа, хувийн сэдэлгүй байсан. Тэнд улс төрийн сонгуулийн үр дүнг эсэргүүцэн иргэд үймээн самуун дэгдээсэн учир эхлээд энэ үйл явдлыг, юу болоод өнгөрсөнийг улс төрчид, улс төр судлаачид шинжлэх ухааны үүднээс үндэслэлтэй тодорхойлох хэрэгтэй, дараа нь хуульчид хууль зүйн талаас нь ямар үйл явдал болсон, хэрхэн зүйлчлэх талаар дүгнэлт гарган хэргийг зөв зүйлчлэх ёстой байсан” гэж байсан нь ч энэ гэмт хэргийг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, сэдэлтийг эрүүгийн эрх зүй судлаачид илүү тодорхой болгох нь хуулийн парктик хэрэглээнд чухал ач холбогдолтой байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлийг гэмт хэргийн тухай хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар сонирхон судалж үзвэл:

17.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх

“1. Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, эсхүл гэмтээсэн бол дөрвөн зуун тооцооны нэгжээс дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Нийтийн эзэмшлийн цахилгаан, дулаан, холбоо, осол гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн бол нэг мянга гурван зуун дөчин тооцооны нэгжээс арван мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁶ “Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл”, УБ.,2012, №3,4, /41,42/, хуудас 45-47

3.Энэ гэмт хэргийг:

3.1. олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар үйлдсэн;

3.2. бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол,

3.3. бусдад их хэмжээний хохирол учруулсан бол дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн зохицуулалтыг оруулсан байна.⁷

Энэ зүйлд мөн адил хохирлын хэмжээ заагаагүй, объектив талын шинжид устгасан, гэмтээсэн идэвхтэй үйлдэл байх гэж заасан байна. Мөн торгох, эрх хасах, хорих гэсэн санкцтайгаас гадна 17 дугаар зүйлийн 18 дахь хэсэгийн 1 дэх заалтыг хүндрүүлэх нөхцөлтэй хуульчлаагүй нь дэвшилттэй байна.

Харин ОХУ-ын эрүүгийн хуулийн 167 дугаар зүйлд:

1. Бусдын эд хөрөнгийн санаатай устгах гэмтээх гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол —хоёр жил хүртэл хугацаагаар хорих эсвэл гурван сар хүртлэх хугацаанд баривчлах, гурван зуун жаран цаг албадан ажил хийлгэх, дөчин мянган рубль эсвэл гурван сарын цалинтай тэнцэх хэмжээний төгрөгөөр тогох шийтгэл оногдуулна.

2. Энэ үйлдлийн улмаас хүний амь нас хохирсон, бусад ноцтой үр дагавар бий болсон эсвэл танхайрах, галдан шатаах, тэсэрч дэлбэрэх бодис ашиглах зэрэг аюултай арга хэрэгслээр үйлдсэн бол — тав хүртэл жилийн хорих ял оногдуулна.⁸ гэж зохицуулсан байна.

ОХУ-ын эрүүгийн хуулийн 167 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж болох их хэмжээний хохирол учирсан бол эрүүгийн гэмт хэрэгт тооцох болон хүндүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчлаагүй нь давуу талтай. Мөн ОХУ-ын эрүүгийн хуульд тусгасантай ижил альтернатив байхаар тогтоох нь оновчтой гэж үзэж байна. Учир нь манай хуульд торгох болон хорих ял оногдуулахаар заасан. Шүүхийн практикт шүүгдэгчийн эдийн засгийн байдал сайн биш байгааг харгалзан үзэж ихэнх тохиолдолд хорих ял оногдуулдаг. Ингэснээр тухайн гэмт үйлдэл, учруулсан хохирол, нийгмийн аюулын шинж чанарын хувьд хэтэрхий хүнд ял шийтгэл оногдуулж байна гэж дүгнэж болно.

Энэхүү өгүүллийн хүрээнд эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх, гэмт хэргийн зүйлчлэл, түүний онол зарчим, үндсэн үзэл баримтлалын талаар тодорхой хэмжээнд хөндөхийг хичээлээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлийг мэргэжлийн хүрээнийхний судалгааны дүнг үндэслэн тухайн зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах болон Улсын дээд шүүхийн тайлбарыг тодорхой ойлгомжтой гаргах шаардлагатай байна. Учир нь тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нэг мөр ойлгож, зөв хэрэглээгүйгээс нийгмийн хор аюулын шинж чанар багатай энэ гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдэл хийсэн олон хүн энэ зүйл ангиар зүйлчлэгдэн ял сонсож байна. Иймээс нэгдүгээрт, хууль тогтоогчийн энэ хэрэгийг хүндрүүлж зүйлчилсэн хүсэл зоргийн илэрхийлэлийг анхаарч тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тодорхой заах, хоёрдугаарт, санкцийн хувьд илүү альтернатив байдлаар оруулах нь оновчтой, гуравдугаарт: хүний амь

⁷ www.parliament.mn/laws/projects/368

⁸ <http://lawtoday.ru/>

насныг үнэгүйдүүлэхгүй байх зорилгоор 153 дугаар зүйлийн 153.2-т заасан "... эсхүл энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон" гэх хэсгийг хасч эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2-т заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулан хуульчлах нэн тэргүүний шаардлагатай гэж үзэж байна.

Мөн эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх гэмт хэргийг тайлбарласан Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарт, тухайн гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх талаар тусгахаас гадна халдлагын зүйлийн онцлог шинжийг тодорхой заах, хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл, сэдэлтийн талаар тодорхой тайлбарлах зүйтэй юм.

Өмчийн харилцаа зохих түвшинд хөгжиж байгаа манай улс орны хувьд хуулиар баталгаажсан өмчийн эрхийг хамгаалах чухал зорилго байгаа хэдий ч хуулийг зөв ойлгож, аливаад бодитой хандах нь нэн тэргүүний асуудал билээ. Хэдийгээр хуульд заасан үүргийн хувьд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллах үндсэн чиг үүрэгтэй боловч иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ч мөн гол чиг үүрэг болохыг хуульчид бид ямагт санах хэрэгтэй байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Ганболд.Б, "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" УБ., 2006 он,
2. Лүндэндорж.Н, "Монголын төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага" УБ.,2002 он
3. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар, УБ.,2013 он
4. "Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл", УБ.,2012, №3,4, /41,42/,
5. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол №33
6. www.parliament.mn/laws/projects/368
7. <http://lawtoday.ru/>